

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 08 сарын 13-ны өдөр

Дугаар

БА-075/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зoorьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолборын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2021/06/17 огноо, 0008692 дугаар, 243/2021
- 2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: БОД-004/2020
- 2.3 Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилга “Б” блок 5 давхар 510 тоот, 11311632 холбоо барих утас, Nhog@invest.ub.gov.mn цахим хаяг;
- 2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Гурванбулаг Сод ХХК оноосон нэр, 9011104142 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5156866 регистрийн дугаар, БУ19-334/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Шинэдэлхий, 7-701 тоот, 77119098, холбоо барих утас;
- 2.5 Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.
- 2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Бес онцгой дизайн ХХК оноосон нэр, 9011331071 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5559634 регистрийн дугаар, ЗТ16-238/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар, 9 дүгээр хороо, Шинэдэлхий, 9-903 тоот, 77334455 холбоо барих утас;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

БАГАР
Хяналт шалгалтын үйлчилгээний байр

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газар оноосон нэр, 9070005075 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9091904 регистрийн дугаар, Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, өөрийн байранд, 70170118 холбоо барих утас;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолборын зориулалттай зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь: Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯНАЛТ ШАЛГ
ГАЗАР

Байгууламжийн
орлуулах ком

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 28 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолборын зориулалттай зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороо,
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай,
зорьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолбор барилга


Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн хэлтсийн дарга



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 42 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ, 3 ДАВХАР,
1 БЛОК, ХОРООНЫ ЦОГЦОЛБОР БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зоорьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолбор барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхрын хурлын танхимд 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 10:00 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн дарга А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар,
Барилга захиалагчийн хэлтсийн дарга Б.Ганзориг
3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт,
аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга
техникийн хяналтын улсын ахлах байцаагч З.Ганбат
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн
стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний
хяналтын улсын байцаагч Э.Цогзолмаа
5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
Техник хяналтын инженер Ц.Билигт
6. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК
Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ
7. Ус сувгийн удирдах газар
Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер Г.Үүрийнгэгээ
8. Нийслэлийн Онцгой байдлын газар,
Зураг хяналтын ахлах байцаагч, хошууч Б.Даваасүрэн
9. Үндэсний төв архив, Зураг төслийн
баримтын ахлах архивч Э.Шижиртуяа
10. Барилгын хөгжлийн төв, Барилга, барилгын
Материалын үйлдвэрлэлийн хэлтсийн
мэргэжилтэн Г.Уртнасан
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг
хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний
ажилтан Б.Даваасүрэн
12. Сонгинохайрхан дүүргийн 42-р хорооны
Засаг дарга Д.Саруул-Ирээдүй
13. “Бес онцгой дизайн” ХХК-ийн архитектор Ч.Давхарбаяр
14. “Гурванбулаг Сод” ХХК-ийн захирал П.Жамсран

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 14

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зoorьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолбор барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **З.Ганбат**:

- Барилгын 1 давхарт тусгаарлах өрөөний гадна шат, зоорийн хэсгийн урд хэсэгт гарсан орц гарцын өөрчлөлтийн зураг гарган зураг төсөв зохиогчийн дүгнэлтэд тусгах. Бусад өөрчлөлтийн зургийг нэгдсэн дүгнэлтэд тусгах /тулгаж харна/
- Гадна тохижилтыг гүйцээх ногоон байгууламж хийх талаар баталгаа өгөх /албан бичиг/
- Хөрсний гадаргын ус зайлуулах сувагчлал хийх талаар зураг гаргаж гүйцэтгэх
- Зоорийн давхарт түвшний өндөржилт гарсан хэсэгт шат бариул хийх
- Суурийн хөрсний уснаас сэргийлэх арга хэмжээг авсан талаар нөхөж үзүүлэх
- Орж ирэх хэсэгт явган зам дагуу хаалт хашлага хийх
- Гадна налуу замын стандартад нийцүүлэх
- Лифт магадлал хийлгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**:

- Узелийн өрөөнд байгаа холигч насосын шугам сүлжээний дулаалгыг бүрэн дуусгаж, өнгийн туузаар ороож хаягжуулах, зарим тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулах
- Өрөөний коллектрууд дотор хог шүүгч суурилуулах
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурилуулах
- Агаар сэлгэлтийг угсарсан ил, далд актыг шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Ц.Билигт**:

- "УБЦТС" ТӨХК-ийн залгах зөвшөөрлийн бичиг
- Дизель генераторыг АЗБТ-д бүртгүүлэх

- Дизель генераторыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн акт
- Цахилгааны ерөнхий самбарын гүйцэтгэлийн зураг
- Цахилгааны ерөнхий самбарт, давхрын самбарт хаяг плакат хийх, схем бирк хийх
- Цахилгааны самбар узелийн тоног төхөөрөмжийн их биеийг газардуулгын хүрээнд холбох
- Техникийн давхарт хүрээг газардуулга хийх
- Аянгын хүрээг зургийн дагуу гүйцэтгэх
- Гадна цахилгаан гүйцэтгэлийн зураг

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Дотор холбоо дохиолол ил далд ажлын акт нөхөж үзүүлэх
- 1 давхрын эрхлэгчийн өрөө, эмчийн өрөөнд зургийн дагуу сүлжээг оруулах
- Зоорь, нэг, хоёр давхруудад зургийн дагуу телефоны үүрийг суурилуулах / хосолсон разетка суурилуулах/
- Давхрын самбаруудын сүлжээний утаснуудыг цэгцэлж хаягжуулах
- Техникийн давхрын галын дохиолол суурилуулах
- Харуулын өрөөний камерын хяналтын төхөөрөмжүүдийг цоожтой ракт суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Гүний худгийн зөвшөөрөл шалгуулах /гольцоог хучих, хөдөлгөөнгүй таглах, гүйцээх/
- Ундны уснаас НЭМБ-т хүсэлт өгч, дүгнэлт шалгуулах /нянгийн үзүүлэлт өгөх/
- Нөөцийн савны хэмжээг багассан L ($V=12.5\text{м}^3$) зурагт $V=16\text{м}^3$ байгаа учраас тайлбар дүгнэлт ирүүлэх
- Нөөцийн савны угаалга, халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгүүлж акт үйлдэж шалгуулах
- Бохир усны гаргалгаа шугамын угсралтын фото акт шалгуулах, халаагч кабелиар ороосон эсэх фото зургаар шалгуулах
- Гадна цэвэр, бохир усны шугамын угсралтын үеийн фото болон ил далд ажлын акт шалгуулах
- Нөөцийн савны шатыг хөдөлгөөнгүй бэхлэх, ус юүлэх үед юүлсэн усыг зайлуулах трап-прямак хийх
- Гүний худаг дээр тоолуур суурилуулах, гэрээ хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл хяналтын ахлах байцаагч

Б.Даваасүрэн:

- Гадна дулаалга хийсэн ил далд фото зураг
- Галын систем холбох, тогоо хомут солих, тэмдэглэгээ хийх, ус тавих шалгах
- Галын дохиоллын систем шалгасан акт фото зураг хавсаргах, зааварчилгаа гаргах
- Зоорийн давхрын гарах хаалга автор тайлбар ирүүлэх
- Давхарын дотор шат хэмжээ алдсан
- Дээвэрт гарах шат хийх
- Гал унтраах анхан шатны багаж MNS5566:2020 стандартын дагуу хийх
- Гидранттай холбоотой тайлбар ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Лифтэнд магадлал хийсэн тухай дүгнэлт техникийн магадлалын актыг хувийн хэрэгт хавсаргах
- Барилга инженерийн байгууламжийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгүүлсэн акт гүйцэтгэлийн зургийг хувийн хэрэгт хавсаргах
- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товьёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм нормативын сангийн төлбөрийн төлөх
- Дээврийн парпед өндөрлөж хаалт хийж гүйцэтгэх
- Өөрчлөлтийн зураг гаргаж баталгаажуулах
- У4-У3 тэнхлэг дагуу зоорийн давхарлуу орох шатанд хамгаалалт өндөрлөгөө хийх
- Барилгад хэрэглэсэн бараа материалын тохирлын гэрчилгээ шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн:**

- Гадна авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний авто машинд зориулсан зогсоолыг стандартын дагуу хийх /босоо тэмдэглэгээтэй/
- Харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замын эхлэл, төгсгөл, эргэлтийг зөв болгож засах

- Авто зогсоолоос явган зам руу дамнуурыг стандартын дагуу
- Гадна үүдний налуу замд 2 талдаа ижил бариул хийх, халтирахаас сэргийлсэн наалт наах, засварлах
- В1 давхрын түвшин зөрүүнд налуу замыг стандартын дагуу хийх
- 2-р давхрын хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөг зургийн дагуу стандартын дагуу хийх
- 1 давхрын хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний бариулыг зөв болгох.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Сонгинохайрхан дүүргийн 42-р хорооны Засаг дарга **Д.Саруул-Ирээдүй:**

- Өрөө, тасалгаа, коридор паркет болгох /хулдаас солих/
- Вакцины өрөөг 2 хувааж тусгаарлах /үзлэгийн өрөө, вакцины өрөө/
- Тариа болон вакцины өрөөний ханыг плита болгох
- Хорооны нийт өрөөний жижиг засваруудыг бүрэн дуусгах
- Зоорийн давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж гарахад бариул хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

“Бес онцгой дизайн” ХХК-ийн архитектор **Ч.Давхарбаяр:**

- Зургийн дагуу галын усны гаргалгаа гаргах Ф76
- Зохиогчийн хяналтаар гарсан үүрэг даалгаваруудийг гүйцээх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

“Гурванбулаг Сод” ХХК-ийн захирал **П.Жамсран:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- БНБД-ийн дагуу зохиогч дүгнэлт шинэчлэн бичих
- БТХ -ын дагуу гүйцэтгэгч тал барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Өргөх байгууламжид байцаагчийн албан шаардлага гаргуулж, засварлах
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилтын ажлыг бүрэн хийх баталгаа албан тоот ирүүлэх.
- Гадна хашаанд зэврэлтээс сэргийлэх таг хаалт хийх
- Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл сунгуулаагүйтэй холбоотой тайлбарыг захиалагч талаас ирүүлэх
- Зоорийн давхрын цонхонд хаалт хийх, шатны хэсэгт бороо цаснаас хамгаалах хаалт хийх.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зоорьтой 3 давхар, 1 блок, хорооны цогцолбор барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч


..... (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар,
барилга захиалагчийн хэлтсийн дарга


..... (Б.Ганзориг)